



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/274

Улаанбаатар хот

Стандартын хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.4 дэх заалт, Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” /MNS 7014:2023/ Монгол Улсын стандартыг эрүүл мэндийн ажилтнуудад танилцуулах, сурталчлахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

2. Байгууллагын түвшинд стандартын хэрэгжилтийг зохион байгуулах сургагч багшийг бэлтгэх сургалтыг 2023 оны 08 дугаар сард багтаан зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д даалгасугай.

3. Эрүүл мэндийн ажилтнууд болон иргэдэд зориулсан мэдээлэл, видео контент бэлтгэн, 2023 оны 08 дугаар сард багтаан холбогдох газруудад түгээхийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (С.Өнөрсайхан)-д даалгасугай.

4. Стандартыг үндэсний түвшинд сурталчлах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, мэргэжлийн арга зүйгээр хангахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (Д.Баярболд)-т үүрэг болгосугай.

5. Стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, 2023 оны IV улиралд Сайдын зөвлөлд танилцуулахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/344, 2015 оны А/189 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141222094